



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэнтий орон сууц ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2023/17/НА-СТА-ОНӨААН**

Цахим хуудас:

[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Чингис хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Н.Туяа  
Утас: 99799709

Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2023-03-30 № 127  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

г **Хязгаарлалттай дүгнэлт** 7

ХЭНТИЙ ОРОН СУУЦ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ О.БАЯРТӨГС  
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий орон сууц ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол дагуу Хэнтий орон сууц ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд анхан шатны баримтгүйгээр 621.0 мянган төгрөгийг зарцуулсан, бараа материалын тайланг гаргаагүй, бэлэн мөнгөний үлдэгдэл 13,627.5 мянган төгрөгийг тоолж баталгаажуулаагүй, анхан шатны баримтгүйгээр 9,356.5 мянган төгрөгийн бараа материалыг зардалд хааж бичсэн, хөрөнгө оруулалтын 310,000.0 мянган төгрөгийн 2 ажлыг тендер сонгон шалгаруулалтгүйгээр гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн, тайлант онд 92,491.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан, шилэн дансны цахим хуудсанд тухайн жилийн 1,615,824.2 мянган төгрөгийн төсөв баталсан тогтоолууд, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шилэн дансны тухай хуулиудын холбогдох заалт, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 260,384.1 мянган төгрөг, авлага 172,000.0 мянган төгрөг, бараа материал 1,912.3 мянган төгрөг, борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө 2,274,312.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 228,220.9 мянган төгрөг, урьдчилж орсон орлого 1,278,289.2 мянган төгрөг, өр төлбөр 22,000.0 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 2,936,829.8 мянган төгрөг байна.

Гэрээт ажлын орлогоос 10,000.0 мянган төгрөг төвлөрүүлж, үйл ажиллагааны зардалд 102,563.7 мянган төгрөгийг зарцуулж, 92,491.7 мянган төгрөгийн алдагдалтай

232330390

ажилласан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,645,098.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: 30 айлын орон сууцны барилгын үлдэгдэл санхүүжилтэд 1,277,008.9 мянган төгрөг, гадна шугам сүлжээний ажилд 19,000.0 мянган төгрөг, гадна цахилгааны ажилд 230,000.0 мянган төгрөг, гадна холбооны шугам сүлжээний ажилд 64,178.9 мянган төгрөг, зураг төсөл, магадлал, геологи, зохиогчийн хяналт, талбай чөлөөлөх зардалд 54,910.1 мянган төгрөгийг гүйцэтгэгч компаниудад олгосон байна.

#### **Аудитын гол асуудал**

Хэнтий орон сууц ОНӨААТҮГ нь 30 айлын орон сууцны барилгыг аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан хугацаанд нь гүйцэтгүүлээгүй, төлөөлөн удирдах зөвлөлөөс ашиг, орлогыг төлөвлөж батлаагүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, төсвөөс олгосон 1,850.0 сая төгрөгөөс 1,800.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, алдагдалтай ажиллаж, үйл ажиллагаа нь холбогдох хууль, дүрэм журамтай нийцэхгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Хэнтий орон сууц ОНӨААТҮГ нь бараа материалын эд хариуцагчийн тайланг гаргаагүй, хөрөнгийг зарцуулан нягтлан бодох бүртгэлд тусгасан нь хууль тогтоомжид нийцээгүй байгааг анхаарах шаардлагатай.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭРДЭНЗБААТАР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,179,509.9	260,384.1
1.1.2	Дансны авлага	0.0	172,000.0
1.1.6	Бараа материал	1,321.0	1,912.3
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	872,124.7	0.0
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.0	2,274,312.5
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,052,955.6</b>	<b>2,708,608.9</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	21,186.0	224,540.0
1.2.2	Биет бус хөрөнгө	309.2	3,680.9
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>21,495.2</b>	<b>228,220.9</b>
1.3	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,074,450.8</b>	<b>2,936,829.8</b>
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
2.1.1	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
2.1.1.1	Дансны өглөг	0.0	0.0
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	295,418.5	1,278,289.2
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.0	22,000.0
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>295,418.5</b>	<b>1,300,289.2</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>295,418.5</b>	<b>1,300,289.2</b>
2.3	<b>Өмч</b>	<b>1,850,000.0</b>	<b>1,800,000.0</b>
2.3.1	-төрийн	1,850,000.0	1,800,000.0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-70,967.7	-163,459.4
2.3.10	Тайлант үеийн ашиг	-70,967.7	-92,491.7
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,779,032.3</b>	<b>1,636,540.6</b>
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>2,074,450.8</b>	<b>2,936,829.8</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	0.0	10,000.0
2	Борлуулалтын өртөг	0.0	0.0
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>0.0</b>	<b>10,000.0</b>
8	Бусад орлого	70.0	72.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	70,968.0	102,419.1
12	Бусад зардал	69.7	144.6
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-70,967.7</b>	<b>-92,491.7</b>
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-70,967.7</b>	<b>-92,491.7</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>-70,967.7</b>	<b>-92,491.7</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>-70,967.7</b>	<b>-92,491.7</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>0.0</b>	<b>1,492,766.1</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.0	10,072.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.0	1,482,694.1
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>69,811.9</b>	<b>2,272,391.9</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	30,278.0	50,275.2
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,735.8	13,252.4
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	5,181.9	1,594,935.6
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	3,140.0	660.0
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,374.0	0.0
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,557.3	4,277.0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	13,544.9	608,991.7
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-69,811.9</b>	<b>-779,625.8</b>
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>295,488.5</b>	<b>0.0</b>
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	295,418.5	0.0
2.1.8		70.0	0.0
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>896,166.7</b>	<b>89,500.0</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,692.0	86,000.0
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	350.0	3,500.0
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	872,124.7	0.0
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-600,678.2</b>	<b>-89,500.0</b>
3	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
3.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>1,850,000.0</b>	<b>0.0</b>
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,850,000.0	0.0
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>0.0</b>	<b>50,000.0</b>
3.2.5	Төсөвт төвлөрүүлсэн	0.0	50,000.0
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,850,000.0</b>	<b>-50,000.0</b>
4.1	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,179,509.9</b>	<b>-919,125.8</b>
5	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>0.0</b>	<b>1,179,509.9</b>
6	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,179,509.9</b>	<b>260,384.1</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан / мянган төгрөгөөр/**

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	<b>2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>1,850,000.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>1,850,000.0</b>
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,850,000.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>1,850,000.0</b>
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	-70,967.7	-70,967.7
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0
8	<b>2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>1,850,000.0</b>	<b>0.0</b>	<b>-70,967.7</b>	<b>1,779,032.3</b>
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0
2	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,850,000.0</b>	<b>0.0</b>	<b>-70,967.7</b>	<b>1,779,032.3</b>
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	-92,491.7	-92,491.7
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	-50,000.0	0.0	0.0	-50,000.0
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0
8	<b>2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>1,800,000.0</b>	<b>0.0</b>	<b>-163,459.4</b>	<b>1,636,540.6</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл / мянган төгрөгөөр /**

Д/д	Дансны нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ажилчдын цалингийн зардал	56,611.9	51,788.4	4,823.5
2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	7,642.6	6,256.1	1,386.5
3	Томилот	1,932.0	897.0	1,035.0
4	Бичиг хэргийн зардал	1,300.0	1,030.5	269.5
5	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	364.8	351.3	13.5
6	Шуудан холбооны зардал	850.0	795.7	54.3
7	Санхүүгийн программ	3,500.0	3,500.0	-
8	Шатах тослох материалын зардал	4,800.0	4,800.0	-
9	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	720.0	720.0	-
10	Хуулийн үйлчилгээ	1,000.0	1,000.0	-
11	Аудитын зардал	1,800.0	900.0	900.0
12	Байрны түрээс, ашиглалтын зардал	4,200.0	4,170.9	29.1
13	Бусад зардал	1,650.0	1,491.5	158.5
14	Маркетингийн зардал	3,000.0	3,000.0	-

15	Барилгын үйл ажиллагаа эрхлэн явуулах Тусгай зөвшөөрөл авах тэмдэгтийн хураамжийн зардал	2,540.0	2,500.0	40.0
16	Цахим тендер зардал	138.0	-	138.0
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>		<b>92,049</b>	<b>83,201.4</b>	<b>8,847.9</b>
<b>Гэрээт инженерийн цалингийн зардал</b>				
17	Ажилчдын цалингийн зардал	8,000.0	6,400.8	1,599.2
18	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	824.0	659.3	164.7
<b>Дүн</b>		<b>8,824.0</b>	<b>7,060.1</b>	<b>1,763.9</b>
<b>Нийт дүн</b>		<b>100,873.3</b>	<b>90,261.5</b>	<b>10,611.8</b>

#### Хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр /

Д/д	Дансны нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Хөрөнгө оруулалт \30 айлын орон сууцны барилга\	1,277,008.9	1,277,008.9	-
2	Гадна шугам сүлжээний ажил /халаалт, халуун хүйтэн ус/	19,000.0	19,000.0	-
3	Гадна цахилгааны ажил / 110кв шугам, 800кв КТП ажил хашааны хамт /	108,000.0	230,000.0	(122,000.0)
4	Гадна холбооны шугам сүлжээний ажил	32,000.0	64,178.9	(32,178.9)
5	Зураг төсөл, зураг төслийн магадлал, геологи, зохиогчийн хяналтын зардал,барилгын талбай чөлөөлөх	78,960.0	54,910.4	24,049.6
<b>Нийт дүн</b>		<b>1,514,968.9</b>	<b>1,645,098.3</b>	<b>(130,129.3)</b>

#### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3,841,920.9 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 641.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2,211,848.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 1,629,451.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

Албан томилолтын зардалд анхан шатны баримтгүйгээр 621.0 мянган төгрөгийг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

##### 5.2 Албан шаардлага

1. Бараа материалын эд хариуцагчийн тайланг гаргаагүй, дэлгэрэнгүй бүртгэлээс зарлагын гүйлгээг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтгүйгээр 9,356.5 мянган төгрөгийн бараа материалыг зардалд бичсэн зөрчил илэрсэнд дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд Шинэ Өндөрхаан хорооллын гадна холбооны шугам сүлжээний ажлыг 80.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-тай, Шинэ Өндөрхаан хорооллын гадна цахилгааны ажлыг 230.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Тэнгэр цэгцрээ ХХК-тай тендер шалгаруулалтгүйгээр гэрээ байгуулсан зөрчил илэрсэнд дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, төсвөөс олгосон 1,800,000.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй, төлөөлөн удирдах зөвлөлөөс тайлант оны эдийн засгийн үзүүлэлтийг батлахдаа борлуулалтын орлого, ашигт ажиллагааг төлөвлөж батлаагүй, тайлант онд 92,491.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан зэрэг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

#### 1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Мөнгөн зарлагын гүйлгээнд түүврийн сорил хэрэгжүүлэхэд оны эхэнд касст 17,600.0 мянган төгрөгийг байршуулснаас 3972.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Бэлэн мөнгөний үлдэгдэл 13627.5 мянган төгрөгийг тоолж баталгаажуулаагүй, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг гаргаагүй, кассын ажиллагааны журамгүй, удаан хугацааны турш бэлэн мөнгөний үлдэгдлийг касст байршуулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4/ мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал болон жижиглэн худалдаалах газар /дэлгүүр, цайны газар, ресторан, бар, зочид буудал гэх мэт/-т байгаа бараа, сав, боодлыг сар бүр /сар бүрийн 1-ээр/; гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын харилцах данснаас шаардлагагүйгээр бэлэн мөнгө гаргахгүй байх, төлбөр тооцоог бэлэн бусаар хийх.

#### Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Томилолтын зардал	1	621.0	1	621.0									
Бараа материал зарлагдсан	1	9356.5			1	9356.5							
Тендер зарлаагүй	1	310000.0			1	310000.0							
Бэлэн мөнгө байршуулсан	1	13627.5					1	13627.5					
Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	1892491.7			1	1892491.7							
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1925852.2</b>	<b>1</b>	<b>621.0</b>	<b>3</b>	<b>2211848.2</b>	<b>1</b>	<b>13627.5</b>					

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Мэдээлэл байршуулаагүй	1	1615824.2						1	1615824.2
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1615824.2</b>						<b>1</b>	<b>1615824.2</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1615824.2</b>						<b>1</b>	<b>1615824.2</b>